



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/315

Арвайхээр

Төсвийн зохицуулалт хийх тухай

Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 “а”, “Аймгийн 2020 оны төсөвт тодотгол хийх тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 13/03 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Аймгийн 2020 оны төсөвт тодотгол хийх тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 13/03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын 9-д заагдсан санхүүжилт 548,000,000 (таван зуун дөчин найман сая) төгрөгийг хасч гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлыг 400,000,000 (дөрвөн зуун сая) төгрөг, мөрийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг санхүүжүүлэх арга хэмжээний зардлыг 148,000,000 (нэг зуун дөчин найман сая) төгрөгөөр тус тус нэмэгдүүлж санхүүжүүлсүгэй.

2.Төсвийн хуваарьт дээрх өөрчлөлтийг оруулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101147